

ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА



2011 ОНЫ 1 САР

МӨНГӨНИЙ БОДЛОГО, СУДАЛГААНЫ ГАЗАР СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

Танилцсан:

Ерөнхийлөгч

Тэргүүн Дэд Ерөнхийлөгч

Дэд Ерөнхийлөгч

МБСГ-ын захирал

Л.Пүрэвдорж

Б.Жавхлан

Н.Золжаргал

Д.Болдбаатар

Хянасан:

МБСГ-ны СХ-ийн захирал

Н.Амар

Боловсруулсан:

СХ-ийн эдийн засагч

СХ-ийн эдийн засагч

СХ-ийн эдийн засагч

А.Ананд


С.Билгүүн

Д.Энхзаяа

ТОВЧ ХУРААНГУЙ

- Инфляцийн хүлээлтийн түүвэр судалгааг 2011 оны 1-р сард Улаанбаатар хотын 1006 иргэд, 392 аж ахуй нэгж болон 12 шинжээчдийг хамруулан явууллаа;
- Иргэд инфляцийг 2011 оны эцэст **17.6%**, аж ахуйн нэгж, байгууллагууд **11.4%**, шинжээчид **15.5%**-д хүрнэ гэсэн хүлээлттэй байна.

Зураг 1 Иргэд, ААН-ийн хүлээгдэж инфляци болон судлаачдын инфляцийн дундаж таамаглал



Сүүдэртсэн хэсэг: иргэд, аж ахуйн нэгжийн хүлээгдэж буй инфляцийн түвшин болон судлаачдын инфляцийн таамаглалыг илтгэнэ

- Түүвэр судалгааны үр дүн иргэдийн дийлэнх нь зээлийн хүүний түвшин өндөр хэвээр байна, мөн хадгаламжинд мөнгөө байршуулахад хараахан тохиромжтой үе биш гэж үзэж байгааг харууллаа. Түүнчлэн ойрын ирээдүйд өрхийн санхүүгийн байдал өнөөдрийн түвшиндөө хэвээр байна эсвэл муудна гэж үзжээ.
- Аж ахуйн нэгжийн дийлэнх хэсэг нь 2010 оны 2-р хагасаас манай орны эдийн засаг сэргэж, иргэдийн худалдан авалт нэмэгдсэн бөгөөд ирэх онд эдийн засаг эрчимтэй өснө гэж хүлээж байна. Эдийн засаг ийнхүү эрчимтэй өснө гэж хүлээж байгаа аж ахуйн нэгжүүд ажлын байраа нэмэгдүүлэх, цалингаа 30% хүртэл өсгөх төлөвлөгөөтэй байгаа нь ажиглагдлаа.
- Шинжээчид 2011 онд эдийн засаг хурдацтай өсч, сарын дундаж нэрлэсэн цалин тасралтгүй нэмэгдэнэ гэж үзжээ. Харин мөнгөний нийлүүлэлт ирэх онд аажмаар буурна гэж таамаглаж байна. Төгрөгийн бусад валюттай харьцах ханш 2011 онд чангарах хандлагатай байна гэжээ.

1. ХЭРЭГЛЭГЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН

Иргэдийн түүвэр судалгааг Улаанбаатар хотын 9 дүүргийн 135 хорооноос 1006 өрхийг санамсаргүйгээр сонголоо. Судалгааны дүнгээр иргэд инфляцийг 2011 оны 1-р улирлын эцэст 18.4%, энэ оны эцэст 17.6% болно гэж хүлээж байна.

1.1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

- Нийт судалгаанд оролцогчдын дийлэнх /62.8%/ нь эмэгтэй;
- Насны бүтцийг харвал судалгаанд оролцогчдын ихэнх /69.0%/ нь 25-54 насны иргэд байгаа нь худалдан авах шийдвэрээ бие даан гаргах чадвартай, үнийн өсөлтийн талаар мэдээлэл сайтай байх магадлалтай юм;
- Боловсролын түвшинг харахад дийлэнх /87.4%/ нь бүрэн дунд болон дээд боловсролтой;
- Ам бүлийн тоог харвал нийт судалгаанд оролцогчдын 81.3% нь 2-5 ам бүлтэй;
- Ажил эрхлэлтийн байдлыг харвал ихэнх /62.0%/ нь хувийн салбарт ажилладаг, мөн 12.7% нь төрийн албанд, 17.8% нь ажилгүй;
- Өрхийн орлогыг харвал 50.7% нь 400 мянгаас доош төгрөгийн орлоготой бөгөөд үүний тал нь 200 мянгаас бага, 38.9% нь 400-800 мянга, 10.4% нь 800 мянгаас дээш орлоготой өрхүүд байлаа.¹

Хүснэгт 1.1 Үнийн хүлээлтийн чанарын хариулт /ирэх 12 сар/

	2008 оны 12 сар	2009 оны 9 сар	2010 оны 1 сар	2010 оны 7 сар	2011 оны 1 сар	
	Хувиар	Хувиар	Хувиар	Хувиар	Тоо	Хувиар
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	23.2%	25.3%	30.7%	21.6%	438	43.5%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	24.6%	32.2%	39.0%	38.8%	243	24.2%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	19.4%	16.6%	10.0%	18.5%	115	11.4%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	9.6%	4.1%	3.1%	5.0%	44	4.4%
5. Үнэ буурна	4.6%	1.4%	0.5%	0.7%	12	1.2%
6. Мэдэхгүй	18.6%	20.4%	16.7%	15.4%	154	15.3%
Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	1006	100.0%

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 1.2 Үнийн хүлээлтийн чанарын хариулт /ирэх 3 сар/

	2011 оны 1 сар	
	Тоо	Хувиар
1. Үнэ өснө, гэхдээ илүү хурдацтай өснө	446	44%
2. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац өөрчлөгдөхгүй	280	28%
3. Үнэ өснө, гэхдээ өсөлтийн хурдац буурна	93	9%
4. Үнэ өөрчлөгдөхгүй	48	5%
5. Үнэ буурна	11	1%
6. Мэдэхгүй	128	13%
Нийт	1006	100%


Эх сурвалж: Монголбанк

1.2. Хүлээлтийн түвшин /чанарын хариулт/

Иргэдийн 79% нь ирэх 12 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэжээ. Үүнээс ойролцоогоор 44% нь одоогийн инфляцийн түвшнээс илүү хурдацтайгаар, 24% нь одоогийнхтой адил түвшинд, 11% нь одоогийнхоос бага хэмжээгээр өснө гэжээ. Харин 4% нь үнэ өөрчлөгдөхгүй, 1% нь буурна гэж хариуллаа /Зураг 1.1/.

Харин иргэдийн 81% нь ирэх 3 сард үнийн түвшин ерөнхийдөө өснө гэж үзэж байна. Үүнээс ойролцоогоор 44% нь одоогийн инфляцийн түвшнээс илүү хурдацтайгаар, 28% нь одоогийнхтой адил түвшинд, 9% нь одоогийнхоос бага хэмжээгээр өснө гэж үзжээ /Хүснэгт 1.1/.

¹ Дэлгэрэнгүй мэдээллийг хавсралт 1 – ээс харна уу.

Зураг 1.1 Ирэх 12 сарын хүлээлт ба инфляцийн түвшин


Эх сурвалж: Монголбанк

Дээрх чанарын хариултуудыг Карлсон-Паркин нарын магадлалын аргаар² тоон утгад хөрвүүлэн тооцвол иргэд 1-р улирлын эцэст жилийн инфляци 18.4%, оны эцэст 17.6%-д хүрнэ гэж хүлээж байна. /Зураг 1.2/-оос харахад өмнөх судалгааны дүнгээр иргэдийн ирэх 12 сарын хүлээлт инфляциас доогуур буюу бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байсан бол энэ удаагийн дүнгээр инфляциас нилээд дээгүүр болж, өсөх хандлага ажиглагдаж байна.

Шигтгээ 1.1. Инфляци өсөх хандлагатай байна

Улаанбаатар хотын ХҮИ 2010 оны эцэст 14.3%-д хүрч хэрэглээний үнэ цаашид өсөх хандлага үргэлжилсээр байна. Инфляцийн хувьд гадаад болон дотоодын хүчтэй дарамтууд хослон нүүрлэж байна. Бусад улсуудын мөнгөний бодлого, хүнсний нийлүүлэлтийн байдал мөн Монгол Улсад хүнсний ногоо, будаа зэрэг хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнүүдийг нийлүүлэгч Хятад улс, ОХУ-д хүнсний үнэ өсч байгаа нь гадаад орчноос инфляцийн дарамтууд ирж болзошгүйг анхааруулж байна. Дотоодын эдийн засгийн хувьд нөөц чадамж дутагдалтай байгаа бөгөөд өнгөрсөн зудны сөрөг нөлөө махны үнэнд ихээхэн нөлөөлсөн хэвээр байна. Түүнчлэн 2011 оны төсөв их хэмжээний бэлэн мөнгө тараах өндөр зардалтай батлагдав. Тиймээс Дэлхийн банкны зүгээс 2011 онд үнийн өсөлтийн дарамтууд үргэлжилнэ гэж үзэж байна.

Эх үүсвэр: Дэлхийн банк /Монгол улсын эдийн засгийн улирлын тойм, 2010 оны 12-р сар/

Зураг 1.2 Иргэдийн инфляцийн хүлээлт /ирэх 12 сарын/

Эх сурвалж: Монголбанк

1.3. Хүлээлтийн түвшин /тоон хариулт/

Иргэдийн 12 сарын дараах хүлээлтийн түвшинг мөн тодорхой тоон завсраас асуух замаар тооцоолол хийлээ. /Зураг 1.3/ –аас харахад хамгийн их /23%/ нь инфляцийг 13-15%-д, дараа /18%/ нь 9-11%-д, мөн /16%/ 11-13%-д байна гэж үзжээ. Мөн зургаас иргэдийн хүлээлт энгийн тархалттай харагдаж байгаа бөгөөд дундаж утгыг олбол 12.1% байна.

Шигтгээ 1.2. Эдийн засаг сэргэж байгаа ч инфляци хурдацтай өсч болзошгүй

Ашигт малтмалын экспортын их өсөлт, хувийн секторын үйл ажиллагааны идэвхжилт ба төсвийн хүчтэй тэлэлтээс шалтгаалан Монгол улсын эдийн засаг сэргэлтийн байдалдаа орж 2011 онд дээд тал нь 10 хувиар өсөх таамаглалтай байна. Энэ нь нэгэнт инфляци өндөр түвшинд очсон эдийн засгийг хэт халааж оны эцсээр инфляци 20 %д хүрч болзошгүй юм. Төсвийн хэт тэлэлт нь эдийн засагт сайнаасаа илүү муу үр дагаврыг дагуулах эрсдэлтэй байна. Засгийн газрын зардал нь ашигт малтмалын бус эдийн засгийн бараг 2/3-т хүрсэн бөгөөд зардлын 35 хувийн энэ өсөлт нь дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадлаас хэт давсан эрэлтийг бий болгож байгаа юм. Үүний үр дүнд инфляци жолоогоо алдаж, бодит ханшны чангаралтыг хурдасгаж хувийн секторыг хохироох болно. Олон улсын туршлага иймэрхүү өндөр инфляци, ялангуяа үндсэн хоол хүнсний үнийн өсөлт нь ядуучуудад хүчтэй нөлөөлдгийг өмнө нь харуулсан билээ. Хэрэв төсвийн хэт тэлэлт зогсохгүй бол Төв Банк инфляциас урьдчилан сэргийлэх алхмуудыг авч, хүүг өсгөж мөнгөний хумих бодлогыг даруй эхлүүлэх нь зүйтэй. Учир нь бодлогын хүү бодит түвшинд аль хэдийнэ хасах болсон бөгөөд инфляци өсвөл улам нэмэгдэх болно.

Эх үүсвэр: Олон улсын валютын сан /Хэвлэлийн мэдээлэл №11/24, 2011 оны 2-р сар/

² Carlson, John A. and Parkin, Michael /1975/: Inflation expectations. "Economica" 42, pp. 123-38.

Хүснэгт1.3 Таны бодлоор ирэх 12 сарын хугацаанд банкны зээлийн хүү хэрхэн өөрчлөгдөх вэ?

	2010 он 7 сар	2011 он 1 сар	Өөрчлөлт
Өснө	21.0	18.0	-3.0
Хэвэндээ байна	31.2	32.5	1.3
Буурна	10.8	17.9	7.1
Мэдэхгүй	37.0	31.6	-5.4
Нийт	100.0	100.0	-

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт1.4 Таны бодлоор ирэх 12 сард төгрөгийн ханш хэрхэн өөрчлөгдөх вэ?

	2011 он 1 сар
Чангарна	35.7
Хэвэндээ байна	45.2
Суларна	19.1
Нийт	100.0

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт1.5 Таны бодлоор ирэх 12 сард хадгаламжинд мөнгө хийхэд тохиромжтой үе мөн үү?

	2010 он 7 сар	2011 он 1 сар	Өөрчлөлт
Тийм	17.1	22.7	5.6
Үгүй	46.0	26.5	-19.5
Мэдэхгүй	36.9	50.8	13.9
Нийт	100.0	100.0	-

Эх сурвалж: Монголбанк

1.4. Бусад асуултуудын дүн

Иргэдийн 18% нь **зээлийн хүү өснө** гэж хариулсан нь өмнөх судалгааны дүнгээс 3 нэгжээр буурсан бөгөөд мөн төдий тооны хүн буурна гэж хариулж өмнөхөөс 7 нэгжээр өсчээ. Хэвэндээ байна гэж 32.5% нь хариулж өмнөхөөс 1.3 нэгжээр өссөн байна. Зээлийн нэрлэсэн хүү нь инфляци болон бодит хүүнээс бүрдэнэ. 2009 оны эцэст инфляци тогворжиж нам түвшинд очсон ч 2010 оны эцэст хоёр оронтой тоонд хүрсэн. Энэ нь зээлийн хүүг бууруулахгүй байх нэг шалтгаан нь гэж хэлж болхоор байна.

Ойролцоогоор 36% нь **төгрөгийн ханшийг чангарна**, 45% нь хэвэндээ, 19% нь суларна гэж үзсэн байна. Сүүлийн жил Монгол улсад орох хөрөнгийн урсгал улам эрчимжиж байгаагаас шалтгаалан ам.доллартай харьцах төгрөгийн ханш аажмаар чангарсаар хямралын өмнөх үеийн түвшинд хүрсэн. 2010 оны 12-р сарын дундаж ханш өмнөх сартай харьцуулахад 3 хувиар, 2009 оны 12-р сартай харьцуулахад 15 хувиар тус тус чангарсан байна.

Судалгаанд оролцогчдын 20 гаруй хувь нь **хадгаламжид мөнгө хийхэд тохиромжтой** гэж үзэж байгаа бөгөөд тохиромжгүй гэсэн хариулт 20 нэгжээр буурч 26%-д хүрчээ. Хадгаламжийн бодит хүү сөрөг³ байгаа ч хадгаламжийн баталгааны хууль болон ханшийн чангаралтаар өдөөгдсөн төгрөгийн хадгаламж өсөх⁴ хандлага үргэлжилсээр байна. Гэвч ам.долларын хадгаламжийн хүү маш өндөр байгаа нь /хугацаатай хадгаламжийн хүү 14 хүртэл хувьтай/ зах зээлийн эрсдэлтэй байдлыг харуулж байгаа бөгөөд хувийн салбарын гадаадаас зээл авах явдал нэлээд их хэмжээгээр нэмэгдлээ. Хэрэв зээлдүүлэгч мөнгөө гэнэт татсан тохиолдолд

³ 2010 оны эцсийн байдлаар хадгаламжийн жигнэсэн дундаж хүүнээс инфляцийн түвшинг хасаж тооцсон бодит хүү -3.6 % байна.

⁴ 2010 оны эцсийн байдлаар төгрөгийн хадгаламж жилийн 62 хувийн өсөлттэй байна.

зээлдэгчийг эмзэг байдалд оруулж болзошгүй юм.

Хүснэгт1.6 Танай өрхийн санхүүгийн байдал ирэх 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх вэ?

	2010 он 7 сар	2011 он 1 сар	Өөрчлөлт
Сайжирна	26.9	22.5	-4.4
Хэвэндээ байна	39.6	37.9	-1.7
Муудна	6.3	15.9	9.6
Мэдэхгүй	27.2	23.8	-3.4
Нийт	100.0	100.0	-

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт1.7 Хэрэв сайжрах бол шалтгаан нь юу вэ?

Хэрэв сайжрах бол шалтгаан нь юу вэ?	Тоо	Хувь
Цалин нэмэгдэнэ	152	15.1
Бизнесийн орлого нэмэгдэнэ	143	14.2
Үл хөдлөх хөрөнгийн үнэ өснө	188	18.7
Өрхийн гишүүн ажлын байртай болно	151	15.0
Үнэ буурна	208	20.7
Төрөөс тэтгэмж, тэтгэлэг авна	181	18.0
Хамаатан, найз нараас тусламж авна	219	21.8
Татварын хөнгөлөлт чөлөөлөлт хүртэнэ	193	19.2
Нийт	1435	142.6

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт1.8 Хэрэв муудах бол шалтгаан нь юу вэ?

Хэрэв муудах бол шалтгаан нь юу вэ?	Тоо	Хувь
Цалин буурна	140	13.9
Бизнесийн орлого буурна	118	11.7
Үл хөдлөх хөрөнгийн үнэ буурна	140	13.9
Өрхийн гишүүн ажилгүй болно	119	11.8
Үнэ өснө	66	6.6
Төрөөс тэтгэмж, тэтгэлэг авахгүй	151	15.0
Бусдад санхүүгийн тусламж үзүүлнэ	151	15.0
Татварын ачаалал ихэснэ	145	14.4
Нийт	1030	102.4

Эх сурвалж: Монголбанк

Иргэдийн **санхүүгийн байдал сайжирна** гэсэн хариулт буурч, муудна гэсэн хариулт огцом өссөн дүнтэй байна. Хэвэндээ байна гэж иргэдийн 37.9% нь хариулсан бөгөөд өмнөхөөс ойролцоогоор 2 нэгжээр буурсан байна. Мэдэхгүй гэсэн хариултын дүн бага зэрэг буурсан байна.

Сайжирна гэж судалгаанд оролцсон иргэдийн 22.5% нь хариулсан бөгөөд давхардсан тоогоор тэдгээрийн ихэнх нь бусдаас тусламж авна, үнэ буурна, татварын хөнгөлөлт чөлөөлөлт хүртэнэ гэж хариулсан боловч ерөнхийдөө жигд хариулсан байна.

Муудна гэж иргэдийн 15.9% нь хариулсан нь өмнөх судалгааны дүнгээс 9 нэгжээр өссөн бөгөөд давхардсан тоогоор тэдгээрийн ихэнх нь төрөөс тэтгэмж авахгүй, бусдад тусламж үзүүлнэ, татварын ачаалал ихэссэнээс, цалин буурснаас шалтгаалан санхүүгийн байдал муудна гэж үзсэн байна.

ДҮГНЭЛТ

Санал асуулгын дүнгээр иргэдийн дийлэнхи нь /80%/ нь үнийн түвшин өснө гэж хүлээж байна. Эдгээр чанарын хариултуудыг тоон утгад хөрвүүлбэл жилийн эцсийн иргэдийн хүлээлт 17.6%-д хүрч, өнөөдрийн инфляцийн түвшингээс өснө гэж үзжээ. Мөн одоогийн байдлаар олон улсын байгууллагууд⁵ жилийн эцэст инфляцийг өндөр байхаар таамаглаж байгаа билээ.

Энэ удаагийн санал асуулгад иргэдийн хүлээлтийг тодорхой тоон интервал өгөн асуусан бөгөөд уг асуултын дүнгээр иргэдийн

⁵ ОУВС-ийн таамаглалаар оны эцэст ойролцоогоор 20 %, Дэлхийн банкны таамаглалаар 25 %д хүрч болзошгүйг анхааруулсан.

хүлээлт нь хэвийн тархалттай байгааг батлан харуулсан. Бусад асуултуудын дүнгээр иргэдийн ихэнх нь ирэх 12 сард зээлийн хүү өсөх буюу хэвэндээ байна, төгрөгийн ханш чангарна, мөн хадгаламжинд мөнгөө байршуулахад хараахан тохиромжтой үе биш хэмээн үзсэн хэвээр байна. Харин тэдний өрхийн орлогын талаар асуухад сайжирна гэсэн хариултын хувь буурч муудна, хэвэндээ гэсэн хариултуудын хэмжээ зонхилох хувийг эзэлж байлаа.

2. АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР СУДАЛГААНЫ ДҮН

Аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд явуулсан инфляцийн хүлээлтийн талаарх түүвэр судалгаа Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй нийт 392 аж ахуйн нэгжийг хамрууллаа. Судалгааны үр дүнгээс харахад аж ахуйн нэгж, байгууллагууд инфляцийг 2011 оны 1 дүгээр улиралд 11.3%, оны эцэст 11.4%-д хүрнэ гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл аж ахуйн нэгжүүд 2011 онд инфляцийн түвшин өнөөдрийн түвшинд хадгалагдана гэж үзжээ.

Хүснэгт 2.1 Аж ахуйн нэгж /өмчлөлөөр/

Аж ахуй нэгжийн хэлбэр	тоо	хувь
Нөхөрлөл	2	0.5
Хоршоо	4	1.0
Хувьцаат компани	20	5.1
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	356	90.8
Төрийн өмчийн үйлдвэрийн газар	3	0.8
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	1	0.3
Бусад	6	1.5
Нийт дүн	392	100.0

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 2.2 ААН-ийн үйлдвэрлэл, үйлчилгээ /салбараар/

Салбарын бүлэг	тоо	хувь
Хөдөө аж ахуй	11.0	2.8
Уул уурхай, олборлох	33.0	8.4
Боловсруулах үйлдвэр	4.0	1.0
Барилга	40.0	10.2
Бөөний болон жижиглэнгийн худалдаа	77.0	19.6
Жижиг, дунд үйлдвэрлэл	40.0	10.2
Зоогийн газар, зочид буудал	49.0	12.5
Тээвэр	16.0	4.1
Бусад үйлчилгээ	122	31.1

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 2.3 ААН-ийн салбарын бүлэг /ажилчдын тоогоор/

Салбарын бүлэг	Ажилчдын тоо /бүлгээр/				
	< 10	11-50	51-100	101 <	Бүгд
Хөдөө аж ахуй	5	4	2	0	11
Уул уурхай, олборлох	13	15	1	4	33
Боловсруулах үйлдвэр	0	3	0	1	4
Барилга	9	20	7	4	40
Б/Ж-ийн худалдаа	58	16	1	2	77
Жижиг, дунд үйлдвэрлэл	25	12	2	1	40
Зоогийн газар, зочид буудал	33	13	1	2	49
Тээвэр	4	11	1	0	16
Бусад үйлчилгээ	86	29	5	2	122
Нийт дүн	233	123	20	16	392

Эх сурвалж: Монголбанк

2.1. Түүвэр судалгаанд оролцогчид

Судалгаанд хамрагдсан нийт 392 аж ахуй нэгж, байгууллагуудын дийлэнх буюу 90.8%-нь хязгаарлагдмал хариуцлагатай хувьцаат компани, 5.1%-нь хувьцаат компани байлаа /Хүснэгт 2.1/.

Түүвэр судалгаанд бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхэлдэг 77 (19.6%), зоогийн газар, зочид буудлын үйл ажиллагаа эрхэлдэг 49 (12.5%), барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 40 (10.2%) болон бусад үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлж буй 122 (31.1%) аж ахуйн нэгжийг хамрууллаа /Хүснэгт 2.2/.

Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийг ажилчдын бүлгээр авч үзвэл 10 болон түүнээс бага ажилчинтай¹ 233 (59.4 хувь), 11-ээс 50 хүртэлх ажилчинтай 123 (31.4%), 51-ээс 100 хүртэлх ажилчинтай 20 (5.1%) болон 100-аас дээш ажилчинтай 16 (4.1%) аж ахуйн нэгж хамрагдлаа /Хүснэгт 2.3/.

¹ Тогтмол хөдөлмөр эрхэлдэг ажилчинтай

Хүснэгт 2.6 ААН-ийн хүлээж буй инфляци /салбараар,12 сарын дараах/

Салбарын бүлэг	Хүлээгдэж буй инфляци
Хөдөө аж ахуй	11.4%
Уул уурхай, олборлох	12.7%
Боловсруулах үйлдвэр	13.0%
Барилга	12.1%
Б/Ж-ийн худалдаа	11.1%
Жижиг, дунд үйлдвэрлэл	11.8%
Зоогийн газар, зочид буудал	12.7%
Тээвэр	12.3%
Бусад үйлчилгээ	12.8%
Хүлээгдэж буй инфляци	12.1%

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 2.7 ААН-ийн өнгөрсөн 6 сар дах эрэлт /бараа бүтээгдэхүүн/

Хариулт	2010 оны 7-р сар		2011 оны 1-р сар		өөрчлөлт хувь
	тоо	хувь	тоо	хувь	
Өссөн	128	32.8	159	40.6	7.8
Өөрчлөгдөөгүй	177	45.4	181	46.2	0.8
Буурсан	85	21.8	52	13.3	-8.5
Нийт дүн	390	100	392	100	-

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 2.8- ААН-ийн ирэх 6 сарын эрэлт

Хариулт	2010 оны 7-р сар		2011 оны 1-р сар		өөрчлөлт хувь
	тоо	хувь	тоо	хувь	
Өснө	145	37.2	184	46.9	9.7
Өөрчлөлтгүй	90	23.1	96	24.5	1.4
Буурна	113	29.0	38	9.7	-19.3
Мэдэхгүй	42	10.8	74	18.9	
Нийт дүн	390	100	392	100	-

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 2.9 ААН-ийн ажлын байр, цалингийн өсөлт

Ирэх 6 сард ажилчдын тоо хэрхэн өөрчлөгдөх вэ?	Ирэх 6 сард цалингаа өсгөх үү?		
	Тийм	Үгүй	Нийт дүн
Нэмэгдэнэ	112	57	169
Өөрчлөгдөхгүй	85	126	211
Буурна	4	8	12
Нийт дүн	201	191	392

Эх сурвалж: Монголбанк

Үнийн ерөнхий түвшин /тоон хариулт/

Судалгаанд оролцсон аж ахуйн нэгж, байгууллагын 12 сарын дараах инфляцийн хүлээлтийн түвшинг тодорхой тоон утгаар асуух замаар санал асуулгын үр дүнг нэгтгэн тооцоо /Хүснэгт 2.5/. Үр дүнгээс харахад 12 сарын дараах хүлээгдэж буй инфляцийн түвшин **12.1%**-тай байна.

2.3. Бусад хариулт

Бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт


Судалгаанд оролцсон аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн болон үйлчилгээний эрэлт өнгөрсөн 6 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн талаар асуухад санал асуулгад оролцогчдын 40.6% нь өссөн, 46.2% нь өөрчлөгдөөгүй, 13.3% нь буурсан гэж хариулсан нь 2010 оны 2-р улиралд явуулсан санал асуулгын дүнтэй харьцуулахад эрэлт өссөн гэсэн хариултын хувь 7.8 нэгж хувиар өсч, харин буурсан гэсэн хариулт 8.5 нэгж хувиар буурсан нь **2010 оны 2-р хагаст манай орны эдийн засаг сэргэж, иргэдийн худалдан авалт нэмэгдсэнийг илтгэж байна** /Хүснэгт 2.7/.

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирэх 6 сарын хугацаанд бараа болон бүтээгдэхүүний хүлээгдэж буй эрэлтийн түвшний талаар асуухад 46.9% нь өснө, 24.5% нь өөрчлөгдөхгүй, 9.7% нь буурна гэж хариулсан нь 2010 оны 2-р улиралд явуулсан санал асуулгын дүнтэй харьцуулахад эрэлт өснө гэсэн хариултын хувь 9.7 нэгж хувь өссөн, буурна гэж хариулсан хариултын хувь даруй 19.3 нэгж хувиар буурсан нь **аж ахуйн нэгж, байгууллагууд эдийн засаг ирэх 6 сард эрчимтэй өснө гэж хүлээж байгаагийн илрэл болно** /Хүснэгт 2.8/.

Ажил эрхлэлт, цалин

Судалгаанд оролцогч аж ахуйн нэгж, байгууллагуудаас “Ирэх 6 сард танай компанийн ажилчдын тоо хэрхэн өөрчлөгдөх вэ?” гэсэн асуулт тавихад санал асуулгад оролцогчдын 169 буюу 43.1% нь нэмэгдэнэ

Зураг 2.3 ААН-ийн цалингийн өсөлт /хувиар/



Эх сурвалж: Монголбанк

гэж хариулсан нь өмнөх судалгааны дүнгээс 20.5 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм.

Түүнчлэн ажлын тоогоо нэмэгдүүлж, ирэх 6 сард цалингаа нэмэгдүүлэхээр төлөвлөж буй нийт 112 аж ахуйн нэгж байна. Харин ажилчдын тоондоо өөрчлөлт оруулахгүйгээр цалингаа нэмэгдүүлэх 85, цалингаа өсгөхгүй байх 126 аж ахуйн нэгж байна /Хүснэгт 2.9/.

Цалингийн түвшингөө ирэх 6 сард нэмэгдүүлнэ гэж хариулсан аж ахуйн нэгжүүдээс цалингийн түвшингөө хэд хүртэл хувиар нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгааг нь тодруулахад цалингаа өсгөх төлөвлөгөөтэй аж ахуйн нэгжүүдийн 91.1% нь цалингийг түвшингөө 30 хүртэл хувиар өсгөх төлөвлөгөөтэй байна /Зураг 2.3/.

Түүвэр судалгааны санал асуулгын үр дүнгээс харахад ойрын хугацаанд шинэ ажлын байр нэмэгдэх магадлал өндөр байгаа бөгөөд, дийлэнх аж ахуйн нэгж ирэх 6 сард ажилчдын цалингаа 30% хүртэл нэмэгдүүлэхээр төлөвлөж байна.

Санхүүжилт болон зээл

Санал асуулгад оролцсон аж ахуйн нэгж, байгууллагуудаас “Ирэх 6 сарын хугацаанд компаниа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байна уу?” гэж асуухад 62.0% нь тийм, 38.0% нь үгүй гэж хариулсан нь 2010 оны 2-р улирлын түүвэр судалгаатай харьцуулахад тийм хариулт 15.7 нэгж хувиар нэмэгдсэн байна /Хүснэгт 2.10/.

Өргөжүүлэх төлөвлөгөөтэй дээрх аж ахуйн нэгж байгууллагуудаас ямар эх үүсвэрээр компаниа өргөжүүлэх талаар асуухад 40.7% нь банкны, 40.3% нь компанийн өөрийн хөрөнгөөр, 9.5% нь гадаад эх үүсвэрээр санхүүжих төлөвлөгөөтэй байна.

Түүнчлэн бичил бизнес² эрхлэгчдийн 43.0% банкны санхүүжилтээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх төлөвлөгөөтэй байгаа бол жижиг дунд бизнес³ эрхлэгчдийн хувьд уг үзүүлэлт 37%-тай байна /Хүснэгт 2.11/. Эндээс

Хүснэгт 2.10 ААН-ийн санхүүжилт авах эх үүсвэр

Санхүүжилтийн хэлбэр	тоо	хувь
Банкны санхүүжилтээр	99	40.7
Компанийн өөрийн хөрөнгөөр	98	40.3
Хувьцаа гаргах	10	4.1
Гадаад эх үүсвэрээр	23	9.5
Санхүүгийн байгууллагын эх үүсвэрээр	10	4.1
Тэтгэлэг, тусламжаар	3	1.2
Нийт дүн	243	100.0

Эх сурвалж: Монголбанк

Хүснэгт 2.11 ААН-ийн санхүүжилт авах эх үүсвэр /ажилчдын тоогоор/

Салбарын бүлэг	Ажилчдын тоо /бүлгээр/				Бүгд
	< 10	11-50	51-100	101 <	
Банкны санхүүжилтээр	61	29	3	6	99
Компанийн өөрийн хөрөнгөөр	55	32	7	4	98
Хувьцаа гаргах	5	3	1	1	10
Гадаад эх үүсвэрээр	11	11	0	1	23
Санхүүгийн байгууллагын эх үүсвэр	6	3	1	0	10
Тэтгэлэг, тусламжаар	3	0	0	0	3
Нийт дүн	141	78	12	12	243

Эх сурвалж: Монголбанк

² Үндсэн ажилчдын тоо 10-аас бага

³ Үндсэн ажилчдын тоо 11-50 хүртэлх

дүгнэхэд бичил болон жижиг дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд нь тодорхой хэмжээний банкны зээлийн хэрэгцээ шаардлагатай байгаа нь түүвэр судалгааны үр дүнгээс харагдлаа.

Аж ахуйн нэгжээс “Ирэх 6 сард танай компанийн зээлийн хэрэгцээ хэрхэн өөрчлөгдөх вэ?” гэж асуухад 42.6% нь нэмэгдэнэ, 52.3% нь өөрчлөгдөхгүй, харин 5.4% нь буурна гэж хариулсан байна. Үүнийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулахад зээлийн хэрэгцээ нэмэгдэнэ гэж хариулсан аж ахуйн нэгжийн тоо даруй 15.2 нэгж хувиар нэмэгджээ.

Хүснэгт 2.12 ААН-ийн ирэх 6 сарын зээлийн хэрэгцээ

Ирэх 6 сарын зээлийн хэрэгцээ	тоо	хувь
Нэмэгдэнэ	166	42.6
Өөрчлөгдөхгүй	205	52.3
Буурна	21	5.4
Нийт дүн	392	100

Эх сурвалж: Монголбанк

ДҮГНЭЛТ

Инфляцийн хүлээлтийн санал асуулгын дүнгээр аж ахуйн нэгж, байгууллагын 2011 оны 4-р улирлын хүлээгдэж буй инфляцийн түвшин **11.4%**-тай байна. Өөрөөр хэлбэл, түүвэр судалгааны үр дүнгээс аж ахуйн нэгжүүд инфляцийн түвшин өнөөдрийн түвшинд хадгалагдана гэж үзжээ.


Түүнчлэн аж ахуйн нэгж байгууллагуудад ойрын ирээдүйд үйл ажиллагаа явуулах болон өргөжүүлэхэд нь санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай байгаа нь түүвэр судалгааны үр дүнгээс харагдлаа. Санхүүжилт шаардлагатай байгаа аж ахуйн нэгжүүдийн дийлэнх хувь банкнаас санхүүжүүлтээ авах сонирхолтой байгаа нь судалгааны үр дүнгээс харагдлаа.

3. ШИНЖЭЭЧДИЙН ИНФЛЯЦИЙН ХҮЛЭЭЛТИЙН ТҮҮВЭР

СУДАЛГААНЫ ДҮН

Шинжээчдийн инфляцийн хүлээлтийн судалгаанд арилжааны банк, их сургуульд ажилладаг нийт 12 шинжээчид оролцов. Уг санал асуулгад эдийн засгийн гол үзүүлэлтүүд (инфляци, M2 мөнгөний өсөлт, төгрөгийн ханш, ДНБ-ий өсөлт, цалин)-ийг багтаасан бөгөөд хариултыг шууд тоон үзүүлэлтээр авч, шинжээчдийн таамгуудын жигнэсэн дунджийг тооцох замаар хүлээлтийг тооцоолов. Судалгааны дүнгээс харахад шинжээчид жилийн инфляци 2011 оны 1-р улиралд 12.5%, эхний хагас жилд 14.9%, оны эцэст 15.5%-д хүрч өсөхөөр таамаглаж байна.


Зураг 3.1 Инфляци



Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийн харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

Зураг 3.2 M2 мөнгөний өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

3.1. Инфляци

Шинжээчдийн таамгаар жилийн инфляци 2011 оны 1-р улиралд 12.5%, эхний хагас жилд 14.9%, оны эцэст 15.5%-д хүрч өсөхөөр хүлээгдэж байна. Энэ нь өмнөх судалгаатай харьцуулахад 1-р улирал ба хагас жилийн инфляци харгалзан 3.3 ба 5.3 нэгжээр өссөн байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2011 оны эцэст инфляци 34.3%, хамгийн бага хүлээлттэй нь 1-р улиралд жилийн инфляци 5.0% байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.1/.


3.2. Нийт мөнгөний өсөлт /M2/

Шинжээчид M2 мөнгөний өсөлт 2011 онд тасралтгүй өсч, 1-р улиралд 32.9%, эхний хагас жилд 41.2%, оны эцэст 49.8%-д хүрнэ гэж тооцоолж байна. Өмнөх судалгаагаар 2011 онд мөнгөний нийлүүлэлт аажмаар буурна гэсэн хүлээлттэй байсан бол энэ судалгаагаар өсөх хүлээлттэй болсон байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2011 оны 3-р улиралд M2 мөнгөний жилийн өсөлт 127.2% , хамгийн бага хүлээлттэй нь 1-р улиралд 10.0% байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.2/.

3.3. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

Шинжээчдийн таамаглалаар төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш тогтмол чангарч, 2010 оны 1-р улиралд 1234.4 төгрөг,


Зураг 3.3 Төгрөг/долларын ханш



Эх сурвалж: Монголбанк
Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.


Зураг 3.6 Сарын дундаж нэрлэсэн цалин

Зураг 3.4 Төгрөг/юаны ханш



Эх сурвалж: Монголбанк
Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

Зураг 3.5 ДНБ-ий жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк
Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

энхий хагас жилд 1206.1 төгрөг, жилийн эцэст 1166.8 төгрөг болохоор тус тус

тооцоолж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад ханшийн хүлээлт огцом буурсан бөгөөд эхний 3 улирлын хүлээлт харгалзан 7.1, 8.5 ба 10.3%-иартус тус буурсан байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2011 оны эцэст төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханш 1300 төгрөг, хамгийн бага хүлээлттэй нь 1000 төгрөг байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.3/.

3.4. Төгрөгийн юаньтай харьцах ханш


Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш мөн 2011 оны турш чангарахаар төсөөлж байна. Өмнөх судалгаатай харьцуулахад юаны ханшийн хүлээлт 2011 оны эхний 3 улиралд харгалзан 6.3, 4.8 ба 7.4 %-иар тус тус буурсан байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2011 оны эцэст төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш 210 төгрөг, хамгийн бага хүлээлттэй нь 130 төгрөг байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.4/.

3.5. ДНБ-ий жилийн өсөлт

Шинжээчид ДНБ-ий өсөлт 2011 оны 1-р улиралд 5.7%, хагас жилд 7.5 хувь, жилийн эцэст 9.7% болохоор таамаглаж байгаа нь өмнөх судалгаатай харьцуулахад илүү хурдтай өснө гэж хүлээж байна. 2011 оны эхний 3-р улирлын таамаг харгалзан 1.9, 2.9 ба 3.8 нэгжээр өссөн байна. Шинжээчдийн таамгаас харахад хамгийн өндөр хүлээлттэй нь 2011 оны эцэст ДНБ-ий өсөлт 30.0%, хамгийн бага хүлээлттэй нь 3-р улиралд 1.6% болохоор тус тус таамаглажээ /Зураг 3.5/.

3.6. Сарын дундаж нэрлэсэн цалин

Шинжээчдийн таамгаар сарын дундаж нэрлэсэн цалин 2011 онд тасралтгүй өсөх буюу 1-р улиралд 2.3 хувиар, хагас жилд 4.2 хувиар, оны эцэст 2.3 хувиар тус тус нэмэгдэж 370.9 мянган төгрөгт хүрнэ гэж тооцоолж байна. Шинжээчдийн таамгаас харахад



Эх сурвалж: Монголбанк
Тайлбар: Сүүдэрлэсэн талбай шинжээчдийн таамгийг харуулах бөгөөд хамгийн их, бага болон дундаж утгуудыг зураасаар дүрслэв.

хамгийн өндөр хүлээлттэй нь 2011 оны эцэст сарын дундаж нэрлэсэн цалин 450.0 мянган төгрөг, хамгийн бага хүлээлттэй нь 299.6 мянган төгрөг байхаар тус тус таамаглажээ /Зураг 3.6/.

ДҮГНЭЛТ

Шинжээчдийн таамаглалаас харахад инфляци, мөнгөний нийлүүлэлтийн өсөлт 2011 оны 1-р улиралд буураад, 2-р улирлаас эхлэн оны эцэс хүртэл өсөхөөр таамаглаж байна. 2011 оны турш ДНБ-ий өсөлт нэмэгдэж, төгрөгийн ам.доллар болон юаньтай харьцах нэрлэсэн ханш чангарахаар төсөөлж байна.